



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/01

Мандалгоми

Г 2018 оныг "Эрүүл мэндийг дэмжих" жил
болгох тухай

Улсын их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030"-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"- г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн амын эрүүл аж төрөх байдлыг хангах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тогтвортой хөгжүүлэх зорилгоор 2018 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласугай.

Хоёр. "Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллан тайланг 2018 оны 06, 12 дугаар сарын 05-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Дөрөв. "Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /А.Нарантуяа/-т, ажлын явц, үр дүнг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /Г.Самданцоодол/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200001

Аймгийн Засаг даргын 2018 оны 21 дүгээр
сарын 14-ны өдрийн 462 тоот
захиралжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Орлогч дарга: Эрүүл мэндийн газрын дарга
Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Мэргэжлийн хяналтын газрын дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Боловсрол, соёл урлагын газрын дарга
Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газрын дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга
Онцгой байдлын газрын дарга
Цагдаагийн газрын дарга
Авто тээврийн үндэсний төвийн дарга
Биеийн тамир, спортын газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нэгдсэн эмнэлгийн дарга
Мандалговь хотын захирагч
ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
ЭМГ-ын Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ны дарга
Ахмадын хорооны дарга
"Дундговь ус" ОНӨҮГ-ын дарга
Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн нэгдсэн холбооны тэргүүн
Улаан загалмайн хорооны дарга
ДЗОУБ-ын Дундговь ОНХХ-ийн багийн ахлагч
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн
Ард телевизийн захирал
Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын НБХ-ийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн